


СХЗГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний
лавлагаа лабораторийн Ерөнхий захирлын
2025 оны 08 сарын 20 өдрийн
А/5 тоот тушаалын 1 хавсралт



УР ЧАДВАРЫН СОРИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дах заалтын дагуу итгэмжлэгдсэн төрийн орон нутгийн болон хувийн өмчит лабораториудад хүнсний микробиологи, химийн чиглэлээр ур чадварын сорилтыг зохион байгуулж, оролцогчдыг үнэлж, тайлагнана.

Хоёр. Зорилго

Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын хими, микробиологийн шинжилгээний үр дүнгийн үнэн зөв байдлыг, шинжилгээний дүнгийн нэгдмэл байдал, хэмжлийн нарийвчлалыг шалгах, гадаад хяналтыг зохион байгуулснаар оролцогч лабораториудын шинжилгээний ур чадварыг дээшлүүлэх;

Гурав. Хамрах хүрээ

Үндэсний түвшинд итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн сорилтын лабораториуд, хувийн өмчит хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн болон эмийн үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хими, микробиологийн шинжилгээний лабораториуд;

Дөрөв. Зохион байгуулах чиглэл

Хими

- Багажит шинжилгээний аргаар ундны усанд нитрит тодорхойлох;
- Уламжлалт шинжилгээний аргаар жигнэмэгт хүчиллэг тодорхойлох;

Микробиологи

- Хүнсний бүтээгдэхүүн, арчдасын бэлдцэд халдварлуулсан бактери тодорхойлох, хөгц мөөгөнцөрийн тоо тоолох,

Тав. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл

Зургаа. Хөтөлбөрийн тайлан

Сорилтын үр дүнгийн тайланг нэгтгэн боловсруулалт хийж оролцогч лабораториудад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дотор хураангуй, дэлгэрэнгүй тайланг Үндэсний итгэмжлэлийн төв, Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлэх, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн nrl.gov.mn цахим хаягт байршуулах;

УР ЧАДВАРЫН СОРИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Хөтөлбөрийн чиглэл	Матриц дээж	Код	Үзүүлэлт	Шинжилгээний аргын стандарт
Хүнсний хими					
1	Багажит шинжилгээний арга	Савласан ус	25-2301	Нитрит	MNS 6779:2019
2	Уламжлалт шинжилгээний арга	Жигнэмэг	25-2302	Хүчиллэг	MNS 0383:2018
Хүнсний микробиологи					
3	Илрүүлэх сорилт	Хиам	25-2523-1	<i>Escherichia coli</i>	MNS ISO 7251:2023
4			25-1423-1	<i>Salmonella spp</i>	MNS ISO 6579-1:2020
5			25-4323	<i>Escherichia coli O157</i>	MNS ISO 16654:2020
6		Хуурай сүү	25-1123	<i>Bacillus cereus</i>	MNS ISO 7932:2023
7			25-2223-1	<i>Staphylococcus aureus</i>	MNS ISO 6888-1:2011
8			25-1923	<i>Listeria monocytogenes</i>	MNS ISO 11290-1:2020
9		Арчдас	25-2523-2	<i>Escherichia coli</i>	MNS 6410:2018
10			25-2223-2	<i>Staphylococcus aureus</i>	
11			25-1423-2	<i>Salmonella spp</i>	
12	Тоо тоолох сорилт	Жимсний нухаш	25-T18	Хөгц мөөгөнцрийн тоо тоолох	MNS 5132:2002